



БНМАУ
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ТОГТООЛ

1989 оны 09
сарын 08 өдөр

дугаар 289

Улаанбаатар
хот

Кино театрт нэр өгөх тухай

1990 онд ашиглалтад орох I хорооллын 600, III хорооллын 1260 хүний суудалтай хоёр кино театрт нэр өгөх асуудлыг хөдөлмөрчдөөр хэлэлцүүлэн санал авсан дунг үндэслэн Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

✓ 1. Нийслэлийн I хорооллын үйлчилгээний цогцолбор дахь 600 хүний суудалтай кино театрыг "Соёмбо", узвэрийн хоёр танхим бүхий III хорооллын 1260 хүний суудалтай кино театрыг "Өргөө" гэж тус тус нэрлэсүгэй.

2. Дээрх кино театруудын нэр хаягийн зураглалыг хийж батлуулахыг хотын ерөнхий зураач н.Ванчиг, ерөнхий архитекторч н.Жадамбаа нарт үүрэг болгосугай.



УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ХАРИУЦ-
ЛАГАТАЙ НАРИИН БИЧГИЙН ДАРГА

С.МОНХЖАРГАЛ

Д.АЛГИА

Д.Алгия



Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх
захиргааны 1989 оны дугаар сарын
нээрийн 189 тоот тогтоолын
хавсралт № I

ОКТЯБРИИН РАЙОНЫ ОСТ-НЫ 18 ДУГААР ХОРООНЫ ГАЗАРТ
ОРСОН АЛДУУДААСХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ААС ГАЧИГДАЛТАЙ ИРГЭДИЙН ШУГАМААР ОРОН СУУЦ
ОЛГУУЛАХ АЙЛУУД

1989-8-30

Овог нэр	Гэрийн хаяг	Хаана ажилла- даг	Амьдралын байдал	Районы санал
I. Буцын Доржготов	ЗАА	АУВХ нэгдэлд харуул	Ам бул II,0-17 насны 9 хүүхэдтэй, эхнэр ХБХН-ийн цайны газар үйлчлэгч, өөрөө группэй, аргагүйн эрхэнд ажил хийж байгаа, 2 нүд нь хараа муутай, 2 хүүхэд нь хараа муутай.	ХГЗ-аас гачигдал- тай иргэдийн шуга- маар байр олгуулах
2. Намсрайн Гансух	ЗАА 8-121	ОК.районы ОСНАА трестэд лифтчин	Ам бул 6,0-17 насны 5 хүүхэдтэй, нөхөргүй, 2 өрөө шавар байшинтай, ах дүү хамаатан садангүй	"-
3. Доржийн Алтангадас	ЗАА 7-107	Барилгын техни- кумын II курсын оюутан	Ам бул 4, эхнэр Цэцэгсайхан ажилгүй, 2-3 насны 2 хүүхэдтэй, хүүхдийн түнх мултарснаас хүүхдээ 3 жил асраад эхнэр нь ПДС-аас хасагдсан, 2 өрөө шавар байшинд суудаг.	"-
4. Ванчиндоржийн Батнасан	ЗАА 9-138	Ш группэд	Ам бул 3,10-17 насны 2 хүүхэдтэй, том хүүхэд нь хэлгүй дүлий, нөхөр нь салсан, айлын байшинд амьдардаг, орох оронгүй	"-
5. Баастын Мартынов	БАА 31-106	ГАМЭҮ-д галч	Ам бул 12, эхнэр 3-20 насны 10 хүүхэдтэй, 2 өрөө шавар байшинд амьдардаг, гэр байшиглаа нүүлгэж чадахгүй.	"-
6. Лувсаншарав Лида	ЗАА 8-130	ЗТК-д билет шалгагч	Ам бул 10, эх, дүү 6-18 насны 7 хүүхэдтэй, нөхөргүй, 2 өрөө шавар байшин, албаны гэрт суудаг	"-
7. Цээсурэнгийн Данзан	БАА 36-173	Тэтгэвэр тог- тоолгож чадааг- гүй.	Ам бул 4, эхнэр 0-3 насны 2 хүүхэдтэй, орон гэргүй зуны байшинд амьдардаг.	"-
8. Чулууны Батжаргал	ЗАА 7-II2	НР районы АҮК-д оёдолчин	Ам бул 3, 12-19 насны 2 охинтой, 2 өрөө шавар байшинтай, нөхөргүй.	"-